



## Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, Бизнесийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Нягтлан бодох бүртгэл

Индекс: D041101

Шинжээчийн баг:

Ахлагч: Ч.Төрбадрах /Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор/

Гишүүд:

П.Уранчимэг /Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн дэд профессор, доктор /

Б.Болормаа / Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, доктор, дэд профессор/

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

## Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөл
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам гэх мэт

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр</b> /Монгол, Англи/	Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр</b> /Монгол, Англи/	Санхүү	
<b>Индекс</b>	D041101	
<b>Шинжээчид</b>	Ахлагч: Ч.Төрбадрах Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор Гишүүд: П.Уранчимэг Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхмийн дэд профессор, доктор Б.Болормаа Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, доктор	
<b>Зохицуулагч</b>	Б.Оюунцэцэг Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.05.09	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. №А/95
	2022.05.10	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2022.05.08	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.05.13,14	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2022.05.30	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2022.06.03	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
	2022.06.03	Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

### Хөтөлбөрийн онцлог:

МУИС-ийн ууган тэнхимийн нэг НББ-ийн тэнхим нь нягтлан бодох бүртгэл бакалаврын хөтөлбөрийг 1958 оноос эхлэн хэрэгжүүлж Монгол улсад НББ-ийн мэргэжилтэн бэлтгэн, тухайн салбартаа үнэтэй хувь нэмэр оруулсан 60 жилийн түүхтэй хамт олон юм.

Нийт 64 дах удаагийн төгсөлтөөр 7200 гаруй оюутан төгссөн. НББ -ийн бакаларын хөтөлбөр нь 2006, 2013 онуудад үндэсний магадлан итгэмжлэл хийгдсэн. 8 жилийн хугацаатай дуусч 2022 онд 3 дах удаагаа магадлан итгэмжлүүлэлт хийгдэж байна.

2013 онд Бизнесийн сургууль нь ACBSP олон улсын магадлан итгэмжлэх байгуулагаар НББ бакалаврын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн.

### Хөтөлбөрийн зорилго:

Шинжлэх ухаанд суурилсан бүтээлч сэтгэлгээ, логик хандлагыг хэрэглэдэг, мэргэжлийн ёс зүйг дээдэлдэг, нягтлан бодох бүртгэлийн онолын болон практик мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмшсэн мэргэжлийн нягтлан бодогчийг бэлтгэх явдал юм.

### Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн PLOs:

PLO <sub>1</sub>	Нягтлан бодох бүртгэлийн шинжлэх ухаан болон бизнесийн бусад судлах зүйлийн хамт мэргэжлийн нягтлан бодогчдын эзэмшвэл зохих мэдлэг
PLO <sub>2</sub>	Техникийн болон мэргэжлийн ур чадвар (зохион байгуулах ба бизнесийн удирдлагын ур чадвар, хувийн ур чадвар, мэргэжлийн шийдэл гаргах ур чадвар, мэргэжлийн болон шаардлагатай программ хангамжуудыг ашиглах чадвар)
PLO <sub>3</sub>	Харилцагчдын хүрээнд үр дүнтэй харилцах
PLO <sub>4</sub>	Тодорхой зорилгод хүрэхийн тулд багаар үр бүтээлтэй ажиллах
PLO <sub>5</sub>	Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлага (хараат бус байдал, найдвартай байдал, шударга ёс, хянамгай байдал, цаг хугацаандаа байх, зөв бодолтой хүндэтгэлтэй байх, хариуцлагатай байх, найдвартай байдал, хууль дүрэм ба зохицуулалтууд, нийгмийн хариуцлагад мэдрэмжтэй хандах)
PLO <sub>6</sub>	Насан туршийн боловсролын хэрэгцээг ойлгох, суралцахыг эрмэлзэх

Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь нийт 120 багц цаг үүний 29,1 хувь ерөнхий боловсролын суурь, 21,6 нь мэргэжлийн суурь, 49,1-нь мэргэжлийн хичээл байна.

д/д	Сургалтын хөтөлбөрийн нэр	Сургуулийн нэр	Батлагдсан огноо	Мэргэжлийн индекс	Нийт судлах багц цаг
1	Нягтлан бодох бүртгэл	МУИС- Эдийн засгийн сургууль	2008	D341400	126
2	Татварын нягтлан бодох бүртгэл		2008	D341500	126

3	Нягтлан бодох бүртгэл	МУИС- Эдийн засгийн сургууль	2010	D341400	120
5	Нягтлан бодох бүртгэл	МУИС- Эдийн засгийн сургууль	2012	D341400	120
6	Нягтлан бодох бүртгэл	Бизнесийн сургууль	2015	D041101	120
7	Нягтлан бодох бүртгэл	Бизнесийн сургууль	2018	D041101	120

### Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

*Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.*

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- МУИС-ын сургалтын журам-2015 оны 6 сарын 30-ны А/203 тоот тушаал
- МУИС-ын 2014 оны хөтөлбөрийн хорооны журам
- Үндэсний болон олон улсын тэргүүлэх их сургуулиудын ижил хөтөлбөртэй харьцуулсан судалгаа
- Оролцогч талуудаас авсан судалгаа
- Хөтөлбөрийн хороо, дэд хорооны хурлын тэмдэглэл
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, дүн шинжилгээ

##### Онцлог зүйл/Туршлага:

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн ACBSP-ийн ахиц дэвшлийн тайлан

2013 оны шинжээчийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн

Дэлхийн тэргүүлэх их сургуулиудтай хөтөлбөрийн харьцуулалт хийсэн

##### Анхаарах асуудал:

Оролцогч талуудын судалгаанд дүн шинжилгээг тасралтгүй хийж, хөтөлбөрийн шинэчлэлтэнд тусгадаг асуудалд анхаарах

##### Зөвлөмж:

Өөрийн сургуулийн хөтөлбөрийн бусад сургуулийн хөтөлбөрөөс ялгагдах онцлог давуу талыг нарийвчлан тодорхойлох

##### Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

#### 1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго,

зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургуулийн болон бүрэлдэхүүн сургуулийн зорилготой уялдуулан, хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулсан
- Төгсөгчийн загварыг боловсруулсан
- Хөтөлбөрийн PLOs болон хичээлийн CLOs уялдаа холбоог нарийвчлан гаргасан

**Онцлог зүйл/Туршлага:**

2015 оноос мэргэжлийн хичээлийн хамтлагуудыг шинчлэн байгуулж, хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх ажлыг хийсэн

**Анхаарах асуудал:**

2015 оноос хойш нэг удаа өөрчлөлт оруулсан байна. Цаашид хөтөлбөрийг сайжруулах тал дээр анхаарах

**Зөвлөмж:**

Сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах асуудалд анхаарах,

**Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Батлагдсан хичээлийн хөтөлбөрүүд
- Тэнхимийн болон хичээлийн хамтлагийн төлөвлөгөө, тайлан
- Сургалтын батлагдсан төлөвлөгөө
- Тэнхимийн гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд /KPI/

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрүүдийн шинэчлэлт хийхдээ олон улсын тэргүүлэх их сургуулиудын төлөвлөгөөтэй харьцуулалт хийдэг, хичээл бүрт сургалтын арга зүйг зааж өгч, хөтөлбөрийн болон суралцахуйн үр дүнгүүдийн уялдаа холбоог нарийвчлан боловсруулсан

**Анхаарах асуудал:**

Тухайн жилийн ажлын тайлангийн анхааруулах асуудал, сайжруулах саналыг дараа жилийн төлөвлөгөөнд тусган тасралтгүй сайжруулахад анхаарах

**Зөвлөмж:**

Тэнхимийн төлөвлөгөө тайланг хэмжигдэхүйц болгох, тэнхимийн зарим бичиг баримтыг стандартын жигд мөрдөх, баталгаажуулалт хийх, /гарын үсэг огноо гэх мэт/

**Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

## 1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

### Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

*Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.*

#### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Илрэл нотолгоо:

- МУИС-ийн “Сургалтын журам”
- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Үндэсний болон олон улсын тэргүүлэх их сургуулиудын ижил хөтөлбөртэй харьцуулсан судалгаа
- МУИС-ийн УЗ-ийн 2015 оны 13-р тогтоолоор баталсан “МУИС-ийн стратеги төлөвлөгөө 2016-2024”
- МУИС Бизнесийн сургуулийн НББ-ийн тэнхимийн 2017-2024 оны стратеги төлөвлөгөө

#### Онцлог зүйл/Туршлага:

- БШУСайдын 2014 оны А/78 тоот тушаалын дагуу мэргэжлийн индексийг өөрчилсөн бөгөөд 2018 онд НББ-ийн хөтөлбөрийг сайжруулж оролцогч талуудын санал асуулгыг тусган зарим хичээлүүдийн улирал, багц цаг зэргийг өөрчлөх, 2019 онд хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээл бүрийн суралцахуйн үр дүнг тодорхойлох, 2021, 2022 онуудад хөтөлбөрийн зорилго, зорилтын шинэчлэл, сургалтын төлөвлөгөөний агуулгын сайжруулалт хэлэлцүүлэг зэргийг тогтмол хийж ирсэн байна.
- Хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгасан хичээлүүдийн залгамж холбоо, уялдааг тодорхойлсон НББ-ийн хөтөлбөрийн хичээлийн уялдааны модыг зураглан харуулсан.
- Суралцагч хөтөлбөрийн шаардлага хангасан тохиолдолд хос, хавсарга мэргэжлээс гадна магистрын хөтөлбөрийн хичээлийг давхар сонгон судлах боломжийг олгодог бөгөөд оюутан 2-р курсээс өөрийн мэргэжлийн зэрэгцээ бусад мэргэжлийн хичээлийг нэмж судлан суралцах боломжтой болно.
- Суралцагч НББ-ийн мэргэжлийн дадлагыг мэргэжлийн заавал судлах хичээлүүдийн агуулгаар, мэргэжлийн багш болон мэргэжилтний удирдлага дор түшиц гадны байгууллага болон дадлагын баазыг ашиглан бүлгээр болон ганцаарчлан явуулдаг.

#### Анхаарах асуудал:

- Дадлагын бааз газруудтай хамтран ажиллахаар хийсэн зарим гэрээнд он сар

өдөр байхгүй,

- Суралцагчдын хийх сургалтын дадлагажуулах явцыг сайжруулахад анхаарах
- Хурлын протокол тэмдэглэгээ хийдэг хавтсанд зарим тэмдэглэгээ дутуу зэрэг дутагдал ажиглагдлаа

**Зөвлөмж:**

- Дадлагын бааз газруудтай хамтран ажиллахаар хийсэн гэрээг он сар өдөртэй болгон баталгаажуулах.
- Танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын агуулгыг сайжруулах

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын арга зүйг хөгжүүлэх, шинэ дэвшилтэт арга зүйг нэвтрүүлэхэд анхаарч, багш нарын ур чадварыг хөгжүүлэх, ажлын үр дүнг үнэлэх тогтолцоо бүрдсэн.
- НББ-ийн хөтөлбөрийн багш нар бакалавр, магистр, докторын түвшний хичээлийн агуулгын ялгаа, ижил төрлийн хичээлүүдийн сэдвийн давхардал зэргийг хянах, хичээлийн хөтөлбөрийг сайжруулан хөгжүүлэхэд анхаарч ажиллах зорилгоор хамтлагийн зохион байгуулалтаар ажилладаг.
- Сургалтанд ашиглаж буй сургалтын арга зүйг хичээл тус бүрээр хийж харуулсан бөгөөд эдгээр аргуудаас онолд суурилсан болон асуудалд суурилсан сургалтын арга зүй давамгайлж байна.

**Анхаарах асуудал:**

- Сургалтын арга зүйн үр дүн ахиц дэвшлийн талаар судалгаа хийж, улирал бүрийн амжилт, чанарын үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулан дүгнэлт хийх байдал дутмаг.

**Зөвлөмж:**

- Сургалтын арга зүйн үр дүнд судалгаа хийн ахиц дэвшил, чанарын үзүүлэлтийн талаар харьцуулсан дүгнэлт хийж байх.
- НББ-ийн хөтөлбөрөөр суралцагчдын мэргэжлийн англи хэл, англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллах

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**



### 2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын 2015 оны А/230 тоот тушаал “МУИС-ийн сургалтын журам”
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Суралцагчийн сурлагын амжилтын талаарх харьцуулсан судалгаа

#### Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-д хөтөлбөрийн явцад оюутны мэдлэг, ур чадвар, хандлагын түвшинг тогтоож, үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлдэг үнэлгээний журам үйлчилдэг бөгөөд НББ-ийн бакалаврын сургалтанд энэхүү журмыг баримталдаг.
- СиСи мэдээллийн систем болон Microsoft Teams платформын аль нэгэнд эсвэл хосолсон байдлаар оруулснаар үнэлгээний ил тод байдал хангагдаж суралцагч өөрийн явцын үнэлгээтэй танилцах боломж бүрдсэн.
- МУИС-ийн хэмжээнд суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг улирал тутам хичээл зааж буй багш бүрээр СиСи мэдээллийн системээр дамжуулан авч оюутны мэдлэг чадварыг бодитой үнэлж байгаа эсэхийг дүгнэдэг байна.
- Суралцагчдын сурлагын амжилт, чанарын үзүүлэлтийг сүүлийн 7 хичээлийн жилээр харьцуулсан судалгаа хийсэн.

#### Анхаарах асуудал:

- Суралцагч оюутны мэдлэг чадварыг бодитой үнэлж байгаа эсэхийг тодорхой хугацааны давтамжтай хийн, харьцуулан дүгнэх байдал дутагдалтай.

#### Зөвлөмж:

- Оюутны мэдлэг чадварыг бодитой үнэлж байгаа эсэхийг тодорхой хугацааны давтамжтайгаар харьцуулан дүн шинжилгээ, анализ хийж, холбогдох талуудад мэдээлж, сургалтын үр дүнг нэмэгдүүлэх

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

*Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.*

### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан /44-51-р хуудас, Хавсралт 3.1-3.7, Хүснэгт 3.1/
- Сургуулийн орчинтой биечлэн танилцсан байдал
- Өөрийн үнэлгээний багийн танилцуулга, PPT
- Холбогдох судалгааны материал
- Хичээлийн сүүлийн 2 жилд СиСи мэдээллийн системээр оюутнуудаас авсан сургалтын орчинтой холбоотой асуулгын дүн
- <https://www.num.edu.mn/Home/Content/>
- <https://data.num.edu.mn/dataset/dormitory>

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хичээлийн 4, 5 дугаар байрны газар, барилга байгууламжийн чанар, стандарт, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагууд болон анги, танхимын норматив, лаборатори, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, засвар үйлчилгээ, ашиглалтын байдал хангалттай.
- Багш, ажилтан, оюутнуудад хэрэглэгдэж байгаа сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчин, утасгүй сүлжээний ашиглалт, хүртээмжийг байнга нэмэгдүүлж, сайжруулснаар багш, ажилтан, оюутнууд сургалт, удирдлагын мэдээллийн системээ ашиглан хичээлийн болон дотуур байр, сургуулийн орчинд утасгүй сүлжээ ашиглах боломж бүрдсэн .
- “Эрүүл-Оюу” нэртэй МУИС-ийн эмнэлэгтэйгээс гадна Бизнесийн сургуулийн дадлагын баазыг байгуулж, сургалтын иж бүрэн программ хангамж бүхий компьютерын лаборатори ашигладаг.

### **Анхаарах асуудал:**

- Оюутнууд бие дааж ажиллах орчныг бүрдүүлэхэд цаашид тасралтгүй анхаарах.

### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

## **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан /51-55-р хуудас, Хавсралт 3.8-3.9/
- Сургуулийн орчинтой биечлэн танилцсан байдал
- Өөрийн үнэлгээний багийн танилцуулга, PPT
- Сургуулийн УМ-ийн СиСи систем, Цахим сургалтын төвтэй биечлэн танилцсан байдал
- МУИС-ийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар батлагдсан “МУИС-ийн цахим сургалтын түр журам”, 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн захирлын А/204 тоот тушаал “МУИС-д судалгааны лаборатори ажиллуулах журам”
- Сургуулийн вебсайт

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Нягтлан бодох бүртгэлийн бакалаврын түвшний сургалтыг зохион байгуулахад шаардлагатай заавар, журмаар хангагдсан байна.
- Сургалтад ашиглаж байгаа техник тоног төхөөрөмжийн хангамж, тэдгээрийн хүчин чадал өмнөх үеүдтэй харьцуулахад сайжирсан байна. Мөн тусгай зориулалтын программ хангамж, дотоод сүлжээний чанар, тогтворжилт, хяналтын аюулгүй байдал, хэвийн найдвартай ажиллагааг хангах тал дээр хангалттай арга хэмжээ хэрэгжүүлэн, ажиллаж байна.
- 2019 оноос “Зардлын нягтлан бодох бүртгэл” хичээлийг МУИС-ийн нээлттэй хичээлийн системд байршуулсан. Мөн МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль бүрээр ашиглаж байгаа TEAMS программ дээр хөтөлбөрийн бүх хичээлүүдийг бүрэн цахимжуулсан.

### **Анхаарах асуудал:**

- Сургалтын хэрэглэгдэхүүний хангамж, хүрэлцээний байдлыг сэтгэл ханамжийн судалгаанд илүү тодорхой тусгах.

### **Зөвлөмж:**

- МУИС-ийн нээлттэй хичээлийн системд байршуулж байгаа НББ-ийн хөтөлбөрийн хичээлийн тоог нэмэгдүүлэх үе шаттай төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.

### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

Өөрийн үнэлгээний тайлан / 59-р хуудас, хүснэгт 3.7, 3.8/

- Сургуулийн болон тэнхимийн номын сантай биечлэн танилцсан байдал
- Өөрийн үнэлгээний багийн танилцуулга, РРТ, шинжээчдэд зориулан бэлтгэсэн ном сурах бичиг, эрдэм шинжилгээний материал
- Номын санд холбогдох судалгааны материал

### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2017 онд ашиглалтад орсон номын сангийн шинэ байр нь номын санд тавигдах шаардлагыг бүрэн хангасан бөгөөд уншигч, өөрөө үйлчлэх хувилах үйлчилгээ, цахим уншлагын танхимтай байна.
- Олон улсын номын сангийн автоматжуулсан КОНА программ хангамж өгөгдлийн бааз ашиглах, е-номын сан ашиглах боломжтой. 390,000 гаруй хэвлэмэл болон цахим бүтээлийн сан хөмрөгтэй, олон улсын онлайн мэдээллийн сан ашиглах боломжтой.

- МУИС-ийн захирлын 2020.04.17-ны А/87 тоот тушаалын дагуу эрдэм шинжилгээний бичиг, номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй докторын судалгааны бүтээлийн 80%-ийг цахим хэлбэрт шилжүүлсэн.
- Ном сурах бичиг 36%-ийн шинэчлэлт хийгдсэн, 60% нь сүүлийн 10 жилд хэвлэгдсэн, 31% нь 2000-2010 оны хооронд хэвлэгдсэн байв. НББ-ийн тэнхимийн багш нар 2016 оноос хойш нийт 14 сурах бичиг гаргасан байна. Үүнээс: ҮОУС-2017, 2019; УСНББОУС гэсэн 3 стандарт 21%-ийг, Улсын секторын нягтлан бодох бүртгэл, хяналт гэсэн сурах бичиг 2 удаагийн хэвлэлт 14,2%-ийг нийтдээ 35%-ийг эзэлж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Үндсэн хичээлийн 60% өөрийн сурах бичигтэй, үлдсэн хувь нь гаднын багш нар болон гадаад эх үүсвэртэй. Номын хүртээмж дунджаар 20 ширхэг байгаа нь хүрэлцээ муутай гэж өөрийн үнэлгээний тайланд дурдсан байв. Иймд хөтөлбөрт хамаарах мэргэжлийн суурь хичээлүүдийн сурах бичиг, ялангуяа багш нарт зориулсан ном сурах бичиг, стандартын хүртээмжийг нэмэгдүүлэх

#### **Зөвлөмж:**

- Ном сурах бичгийн судалгааг хөтөлбөрт тусгагдсан хичээл бүрээр гаргаж, дутагдалтай сурах бичгийг илрүүлж, нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх.
- Цахим сургалтын орчин, цахим боломжуудыг ашиглах (гадаад, дотоодын ном сурах бичгийг цахим хэлбэрээр авах) чиглэлд илүү үр бүтээлтэй ажиллах

#### **Шаардлага:**

**Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: бүрэн хангасан.**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

*Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.*

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- МУИС Бизнесийн сургуулийн НББ-ийн тэнхимийн хөтөлбөрийн хорооны 2016-2021 оны хурлын тэмдэглэлүүд
- МУИС-ийн УЗ-ийн 2015 оны 13-р тогтоолоор баталсан “МУИС-ийн стратеги төлөвлөгөө 2016-2024”.
- МУИС Бизнесийн сургуулийн НББ-ийн тэнхимийн 2017-2024 оны стратеги төлөвлөгөө
- Захирлын 2018 оны А/452 тоот тушаал “Хөтөлбөрийн журам боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай”.
- МУИС-ын захирлын 2016 оны 12 дугаар сарын 23-ны А/347 тоот тушаал “МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журам”
- Бакалаврын хөтөлбөрт хамаарах оюутнуудын өргөдлүүд
- СиСи систем
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр сайжруулахтай холбоотой Хөтөлбөрийн хорооны түр журам (захирлын 2014 оны 3-р сарын 7-ны өдрийн А/55 тоот тушаал) боловсруулж, сургалтын хөтөлбөрийг хөтөлбөрийн хороод боловсруулдаг, хэлэлцдэг, хянан сайжруулдаг системийг Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд анхлан нэвтрүүлсэн байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бодлогын болон эрх зүйн 13 дүрэм, журмыг өөрсдийн онцлогт нийцүүлэн баталж, сайжруулан шинэчилж, мөрдүүлж байна. МУИС-ийн 2011-2020 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, нөхцөл байдлыг үнэлэн “МУИС-ийн стратеги төлөвлөгөө 2016-2024”-ийг 2015 онд УЗ-ийн 13-р тогтоолоор баталсан. Үүний дагуу МУИС-ийн Бизнесийн сургуулийн НББ-ийн тэнхимийн 2017-2024 оны стратеги төлөвлөгөөг батлуулан мөрдөж байна. Хичээлийн жил бүрийн эцэст тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган Бизнесийн сургуулийн болон МУИС-ийн тайланд нэгтгэгддэг байна.
- 2018 онд А/452 тоот тушаалаар Хөтөлбөрийн журам боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Өнгөрсөн 8 жилийн хугацаанд тэнхимийн

хөтөлбөрийн хороо 16 удаа хуралдаж, хөтөлбөрийн сайжруулалттай холбоотой асуудлыг голчлон хэлэлцсэн байна.

- Багш нарыг 3 жил тутамд аттестатчилдаг бөгөөд мөн МУИС-ийн захирлын 2019 оны А/52 тоот тушаалаар батлагдсан “Багшийн хөгжлийн хөтөлбөр 2019-2024”-ийг хэрэгжүүлж эхэлсэн нь багш нарын ур чадвар, мэдлэг, өөрийгөө хөгжүүлэхэд чанарын ахиц гаргахад чухал нөлөө үзүүлж байна.
- Оюутнуудаас хөтөлбөртэй холбоотой санал, гомдол ирээгүй байх бөгөөд 2021 онд хийсэн сургалтын үйл ажиллагааны талаар болон оюутан хангалттай мэдлэг эзэмшиж байгаа эсэх талаар хийсэн санал асуулгад 229 оюутан санал ирүүлснээс 90,9 хувь нь хангалттай сайн гэсэн үнэлгээ өгсөн байна.
- МУИС нь сургалт, мэдээллийн СиСи системийг нэвтрүүлснээр сургалтын бүхий л үйл ажиллагааг шуурхай, ил тод, талуудын хяналт дор явуулах боломжтой болсон байна.

#### **Зөвлөмж:**

- НББ-ийн тэнхимийн 2017-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын дүн шинжилгээ хийж, мэдээлдэг байх
- Сургуулийн хэмжээнд хийгдэж байгаа аливаа судалгаа, гүйцэтгэсэн ажил, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, мэдээлдэг байх.

#### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Бизнесийн сургуулийн бизнес төвийн 2018-2021 оны ажлын гэрээ, хэлцэл
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС нь 2021 оны байдлаар дэлхийн 36 улсын 217 их дээд сургууль, бизнесийн болон бусад чиглэлийн байгууллага, дотоодын 54 их дээд сургууль, байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг үзэглэн ажилладаг байна. Энэхүү давуу талыг тэнхим ч мөн адил ашиглах боломжтой. МУИС-ын Бизнесийн сургууль нь 2015-2021 онд 70 төсөл, гэрээт ажил хэрэгжүүлсний 16 нь Нягтлан бодох бүртгэлийн тэнхимд хамаарч байна. Тухайлбал, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш нарын оролцоотойгоор 2018 онд Багануур ХК-ийн хангамжийн бараа материалын үлдэгдлийн оновчтой тоо хэмжээг тогтоох, 2020 онд “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-ын нөөцийн удирдлагыг сайжруулах судалгааны ажил, 2021 онд Гадаад харилцааны яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах, “Газком”

ХХК-ийн өртөг тооцох аргачлал боловсруулах чиглэлээр тухайлбал 4 гэрээт ажлыг нийгэмд чиглэсэн үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлсэн байна.

- ОХУ-ын Эрхүү хотын БГУиП сургуультай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд тус тэнхимийн 5 багш мэргэжил мэдлэгээ дээшлүүлсэн байна. ММНБИ, ММҮИ зэрэг мэргэжлийн ТББ-тай санамж бичиг байгуулан, идэвхтэй ажилладаг.
- 2015-2021 онд НББ-ийн ангийн 13 оюутан, 2 докторант багш МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг, 20 оюутан дотоод гадаадын хувь хүн, сангийн нэрэмжит тэтгэлэгт тус тус хамрагдсан байна.

#### **Анхаарах асуудал:**

1. Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах, эргэх холбоотой ажиллах үйл ажиллагааг эрчимжүүлэх.
2. Польш улсын LODZ -ийн их сургуультай нягтлан бодох бүртгэл, санхүүгийн чиглэлээр бакалаврын 2+2 хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн боловч нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр оюутан хамрагдахгүй байгаад дүн шинжилгээ хийх.

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийн холбоотой хамтран кейс сургалтыг хөгжүүлэх, ажиллаж байгаа нэгж бүр дээрээ оюутныг дадлага хийлгэх бааз суурь болгож, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Гадаадын их дээд сургуулиудтай хөтөлбөрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх
- Мэргэжлийн нийгэмлэг, байгууллагатай хамтарч ажиллах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх,

#### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Бизнесийн сургуулийн төсөв, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн оюутнуудын 2018-2021 оны бакалаврын түвшний орлогын тооцоо, нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн 2018-2021 оны мөнгөн зарлагын тооцоо
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн хэмжээнд төсвийн төлөвлөлт, орлого хуваарилалт, бүтээгдэхүүний өртөг тооцооллын шинэ журамд шилжин ажиллаж байна. МУИС-ийн Бизнесийн сургуулийн төсөвт зардлын гүйцэтгэлийг нэгдсэн байдлаар тайлагнадаг, Нягтлан бодох бүртгэлийн тэнхим жил бүрийн төсвийн саналаа УЗ-д хэлэлцүүлэхээр хүргүүлдэг. Бизнесийн сургуулийн зардлын дүнд НББ-ийн

тэнхимийн зардлын эзлэх хувь 2016 онд 20,8%, 2017 онд 51,5%, 2018 онд 37%, 2019 онд 23,3%, 2020 онд 5,6%, 2021 онд 9,3%-ийг тус тус эзэлж байна. НББ-ийн тэнхимийн хөтөлбөрт санал өгсөн суралцагчийн тоо/сонголт, баталгаажуулалтын байдал 2016 онд 446/180, 2017 онд 428/185 байсан бөгөөд сүүлийн жилүүдэд хуваарийн баталгаажуулалт 100 болтол, мөн идэвхтэй суралцаж байгаа оюутны тоо 2018 оноос хойш буурсан үзүүлэлттэй байна. Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн орлого, зардал, төсвийн гүйцэтгэлийг тусгайлан гаргадаггүй тул оюутны тоо, санхүүгийн зарим үзүүлэлтийг Хүснэгт 1-ээр харуулав.

### Хүснэгт 1

	2018 он	2019 он	2020 он	2021 он
НББ-ийн тэнхимийн хөтөлбөрт санал өгсөн суралцагчийн тоо/сонголт, баталгаажуулалт	371/150	252/100	303/100	100
Идэвхтэй суралцаж байгаа оюутны тоо	512	523	481	429
НББ-ийн хөтөлбөрийн оюутнуудын сургалтын орлого (сая төг)	862,5	967,5	866,5	759,4
НББ-ийн тэнхимийн эрдэм шинжилгээний зардал (сая төг)	67,4	71	19,9	28,5
НББ-ийн тэнхимийн багш нарын судалгааны суурь зардал (сая төг)	12	11	12	13

- Төгсөгчид, хамтран ажилладаг байгууллагуудтай төсөл, гэрээт ажлыг гүйцэтгэж, гүйцэтгэлийн тодорхой хувийг сургалтын орчныг сайжруулах зорилгоор хандив тусламж биет хэлбэрээр авах хэлбэр байна. Төр хувийн хэвшлүүд нэрэмжит тэтгэлэг олгох, оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, нэрэмжит лаборатори, өрөөг тохижуулах зэрэг нь санхүүгийн дэмжлэгийн нэг хэсэг болдог байна.

#### Анхаарах асуудал:

- Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн орлого, зардал, төсвийн гүйцэтгэл, нэг оюутанд ногдох өртөг, зардлын тооцоо зэргийг нарийвчлан гаргах

#### Шаардлага :

- Хөтөлбөрт суурилсан төсөв зохиох, санхүүгийн болон санхүүгийн бус үр дүнг хөтөлбөрт суурилж тайлагнадаг байх .

#### Шалгуурыг хангасан байдал: хэсэгчлэн хангасан

#### 4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.



### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- МУИС-ийн захирлын тушаалаар батлагдсан “Маркетингийн төлөвлөгөө”
- Сургуулийн болон тэнхимийн цахим хуудас, танилцуулга материал
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн болон тэнхимийн цахим хуудас, СиСи сургалт удирдлагын мэдээллийн систем, танилцуулга материал, НББ-ийн тэнхимийн Journal of Accounting Theory and Practice сэтгүүлийн цахим хуудас, эрдэм шинжилгээний бүтээл, Аккаунт клуб, фейсбүүк хаяг зэргээр мэдээллийг хүргэдэг.
- Маркетингийн идэвхжүүлэлтийн бүхий л арга хэлбэрүүдийг ашигладаг, хөтөлбөр сурталчлах үйл ажиллагааг байнга зохион байгуулдаг.
- Багш удирддаг оюутны клубээр дамжуулан элсэгчдэд таниулга хийдэг.

### **Анхаарах асуудал:**

- “Маркетингийн төлөвлөгөө”-ний биелэлтийг дүгнэж, хөтөлбөр хариуцсан тэнхимийн болон багш нарын оролцоог хангах нэмэгдүүлэх

### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- сургуулийн веб хуудас, танилцуулга материал, эрдэм шинжилгээний бүтээл, самбар
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд ил тод мэдээллийг хүргэж хэвшсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

#### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: бүрэн хангасан**

### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

*Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.*

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- БШУСайдын 2013 оны А/79 тоот тушаал “Оюутан элсүүлэх журам”
- БСШУС сайдын 2018 оны А/194 тоот тушаал “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”
- МУИС-ийн УЗ-ийн 2015 оны 13-р тогтоолоор баталсан “МУИС-ийн стратеги төлөвлөгөө 2016-2024”.
- МУИС Бизнесийн сургуулийн НББ-ийн тэнхимийн 2017-2024 оны стратеги төлөвлөгөө
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

**Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС 2015 оноос эхлэн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгчдийг тодорхой мэргэжлийн хөтөлбөрт бус харин бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэн элсүүлээд хөтөлбөртэйгээ танилцсаны дараа мэргэжлээ сонгох нь оновчтой гэж үзэн нэг хичээлийн жилийн дараа мэргэжил сонгуулдаг байна.
- НББ-ийн тэнхимийн зүгээс БС дээр хөтөлбөр сурталчилахдаа РРТ файлаар танилцуулга хийхээс гадна, номын хавчуурга, брошюр зэрэг тараах материал бэлтгэн танилцуулдаг.
- МУИС-ийн БС-ийн НББ-ийн бакалаврын хөтөлбөрт 2015-2016 оны хичээлийн жилд нэг гадаад оюутан суралцсан. Үүнээс хойш гадаад оюутан нэмж элсээгүй байна.

**Анхаарах асуудал:**

- Сургалтын үйл ажиллагаа, арга зүйн шинэчлэл хийж буй талаар сурталчилах, хөтөлбөрийн давуу тал боломжийн талаарх мэдээлэл дутмаг
- НББ-ийн хөтөлбөрөөр гадаад оюутан элсүүлэн суралцуулах байдал орхигдсон.

**Зөвлөмж:**

- НББ-ийн хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа, давуу тал, боломжийг сурталчлан элсэгчдийг татах, оройн болон эчнээ, бямба гарагийн ангиудын элсэлтийг нэмэгдүүлэх
- НББ хөтөлбөрөөр гадаад оюутан элсүүлэн суралцуулах байдалд анхаарал хандуулах

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн УЗ-ийн 2015 оны 13-р тогтоолоор баталсан “МУИС-ийн стратеги төлөвлөгөө 2016-2024”.
